

ГЕРМАНЫ ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖИЛ ДЭВШИЛ

Германы эдийн засгийн хөгжлийн чиг хандлага

*Орчуулсан Олон Улсын эдийн засаг, бизнесийн
дээд сургуулийн багш, магистр Р. Буянжаргал
“БИКИ” сэтгүүл. 2002 он №3*

Герман улс удирдлагын зардлаа аль болох багасгах, хүн амын орлогын албан татварыг бууруулах замаар тус орны эдийн засгийн өсөлтийн хурдыг хэлбэрэлтгүй өсгөхийг эрхэмлэж байна.

Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага(ОЕСД)-ын шинжээчдийн тооцоогоор Герман төсвийн алдагдлаа багасгаж чадвал 2003 онд төсвийн алдагдал Дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/-ний 1,75%-д хүрэх төлөвтэй гэж үзсэн байна. Харин 2002 онд ДНБ-ний өсөлтийн хурд буурч байна. Энэ хугацааны дунд үе хүртэл экспорт өссөн боловч цааш өсөх хандлага ажиглагдахгүй байна. Гэвч Дэлхийн Худалдааны Байгууллагын үйл ажиллагаатай шууд уялдуулан 2002 оны сүүлчээс эхлэн экспортоо сэргээх зорилттой ажиллаж байна. ОЕСД-ын шинжээчид хувийн хэрэглээнд хэрэглэгчдийн итгэх итгэл буурч, ажилгүйдэл өсч байгаатай уялдаад экспорт нэлээдгүй өснө гэж үзэж байна.

Ажилгүйдлийн төвшин 2000 онд 7,5% хүртэл өссөн бол 2002 онд 8,1% хүрэх төлөвтэй. Тухайн хугацаанд мөнгөний ханш үргэлжлэн буурч 2002 онд шууд татвар нэмэгдэх болсныг ажиглан энэ хандлагыг яваандаа өөрчлөх зорилготой байна.

Одоо тус орны эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн хөгжлийн байдал төлвийг авч үзье.

(тэрбум евроор тооцсон хувь)

Дл	Үзүүлэлт	2001	2002	2003
1.	ДНБ	0,7	1,0	2,9
2.	Ажилгүйдэл	7,5	8,1	8,0
3.	Төсвийн үлдэгдэл (ДНБ-д эзлэх хувь)	-2,5	-2,5	-1,8
4.	Төлбөрийн тэнцлийн алдагдал (ДНБ-д эзлэх хувь)	0,7	0,4	0,3
5.	Хувийн хэрэглээ	1,5	1,4	2,4
6.	Улсын хэрэглээ	1,3	1,2	1,2
7.	Үндсэн капиталд оруулсан хөрөнгө оруулалт	-2,6	-0,7	3,1
8.	Дотоодын нийт эрэлт	0,1	1,1	2,7
9.	Экспортын бараа үйлчилгээ	5,1	3,0	7,0
10.	Импортын бараа үйлчилгээ	2,9	3,6	6,7

Энэ судалгаанаас харахад Германы ДНБ 2001 оноос 2002 онд 0,9%, 2002 оноос 2003 онд 1,9%-иар, импорт мөн үед 0,7% ба 3,1%-иар тус тус өсөх бололтой.

Германы гадаад эдийн засгийн сэргэлт

«БИКИ» сэтгүүл 2002 он, №42

ХБНГУ-ын гадаад худалдааны өнөөгийн байдал

(тэрбум дойч марк /DM/)

Дл	Үзүүлэлт	1999 он	2000 он	2000/19 99	2001 он	2001/20 00
1.	Бараа эргэлт	1867,5	2221,5	119,0	2308,9	103,9
2.	Экспорт	997,5	1168,6	117,2	1246,3	106,6
3.	Импорт	870,0	1052,9	121,0	1062,6	100,9
4.	Үлдэгдэл	127,5	115,7	-	183,7	-

Энэ судалгаанаас харахад Германы бараа эргэлтийг 2000/1999 онтой харьцуулахад 19% өссөн боловч 2001/2000 онтой харьцуулахад 3,9% өссөн нь өмнөх үеэсээ даруй 15,1% буурсан байна. Харин үлдэгдэл нь 2000 оноос 2001 онд 68,0 тэрбум DM-аар өссөн байна.

Германы нефтийн импорт

«БИКИ» сэтгүүл, 2002 он №20-21

Эдийн засаг, экспортын хяналт холбооны байгууллагын мэдээлснээр тус улсын нефтийн импорт 2000 онд 103,6 сая тн байсан бол 2001 онд 1,4% өсч 105,0 сая тн-д хүрч нэмэгдсэн. Харин нийт зардал нь 2362 тэрбум евро хүрсэн ч 21,2 тэрбум еврогоор буурчээ. Дундаж үнэ нь 2000 онд 227,22 евро байснаа 11,3% хямдарч, нэг тонн нь 201,60 евро хүрлээ. ОХУ-аас Германд нийлүүлж байгаа нефть 2001 онд 1,8% өссөн ба энэ нь ХБНГУ-ын нийт импортийн 28,9%-ийг эзэлж байна.

Герман улсад нефть импортлогч орнууд

(МЯН ТН)

Дд	Нефть импортлогч орнууд	2000 он	2001 он
1.	ОХУ	29754	30303
2.	Норвеги	18579	20871
3.	Англи	13041	15323
4.	Ливи	11843	10028
5.	Сири	7092	7312
6.	Казахстан	3435	4637
7.	Саудын Араб	4568	4016
8.	Алжир	6501	3932
9.	Нигери	1983	3013
10.	Венесуэл	1881	1670
11.	Дани	867	1050
12.	Азербайжан	1001	881
13.	Конго	255	752
14.	Ангол	446	318
15.	Иран	908	256
16.	Тунис	154	133
17.	Бразил	-	126
18.	Кувейт	643	109
19.	Итали	100	98
20.	Австри	57	63
21.	Нидерланд	-	55
22.	Египет	-	29
23.	Ирак	220	21
24.	Йемен	103	-
25.	Судан	82	-
	Бүгд	103555	104997

Энэ судалгаанаас ажиглахад 2001 онд Германы нефтийн импортод ОХУ 28.8%, Норвеги 19.9%, Англи 14.6%, Ливи 9.5%, Сири 6.9%, Казахстан 4.4%, Саудын Араб 3.8%, Алжир 3.7%, Нигери 2.9%, Венесуэл 1.6%-ийг тус тус эзэлж байна.

Германы эрчим хүчний хэрэглээ

«Arbeitsgemeinschaft Energiebilanzen» хэмээх ХВНГУ-ын байгууллагын хийсэн тооцоогоор Германы эрчим хүчний хэрэгцээ 2000 онтой харьцуулахад 2001 онд 1,6% өсч 495 сая тн-д хүрчээ. Энэ өсөлтийн үндсэн шалтгаан бол өвөл цаг уурын байдал хүйтэн байсан явдал бөгөөд цаашид эрчим хүчээ гамнахын чухлыг дурдсан байна.

Эрчим хүчний хэрэглээнд ихэнхи хэсгийг юуны өмнө нефть эзэлдэг байна. Цаашид байгалийн хийг ашиглах чиг хандлагаа өсгөх сонирхолтой байна.

Германы эрчим хүчний хэрэглээний байдлыг авч үзье.

(сая тн)

Дл	Үзүүлэлт	1990 он	1995 он	2000 он	2001 он
1.	Бүгд	508,8	486,9	487,2	494,8
2.	Нефть	178,7	194,1	187,3	190,3
3.	Байгалийн хий	79,0	96,5	102,2	106,6
4.	Чулуун нүүрс	78,7	70,3	68,5	65,0
5.	Цөмийн түлш	56,8	57,4	63,1	63,7
6.	Хүрэн нүүрс	109,2	59,2	52,8	55,6
7.	Усан болон салхины эрчим хүч	2,0	2,8	3,6	3,8
8.	Бусад	4,4	6,6	9,7	9,9

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНИК ГЕРМАНД

Үнэр ханхлуулагч компьютерийг зохнон бүтээлээ

Орчуулсан Ц. Лхам

<http://www.fit-1.de/HiFiMM/MCZW54E66G5>

16.08.2002

Компьютер дээр хэдэн цагаар ч хамаагүй ажиллах үе бидэнд бишгүй л тохиолддог. Энэ үед таны компьютерээс анхилуун цэцэгс болон нялх ногооны үнэр ханхалж байвал хичнээн таатай байх бол оо! Энэ бол мөрөөдөл биш, үнэхээр ийм цаг үе бидний хаяанд ирчихээд байна. Мэдээллийн технологи, компьютерийн мэргэжлийн сэтгүүл болох "ComputerPartner"-ийн сүүлчийн дугаарт ХБНГУ-ын Мюнхен хотноо орших Comscent фирм компьютерээс үнэр ханхлуулдаг программыг зах зээлд гаргах гэж байгаа тухай мэдээлсэн байна. Уг фирм "Sniffman" буюу Шнифман хэмээх үнэр ханхлуулах программыг өдгөө олон тоогоор үйлдвэрлэхээр зэхэж буй бөгөөд Шнифман нь 32 төрлийн үнэрийг гаргах чадалтай гэнэ. Жишээ нь энэ нь шинэхэн кофены үнэрээс эхлээд дугуйны хаймрыг үрэхэд гарах үнэр гэх мэт 32 төрлийн үнэрийг гаргадаг ажээ.

Үнэрт бодис жижиг жижиг савнуудад шингэн хэлбэрээр хадгалагдах бөгөөд таны өгсөн командын дагуу аль нэг жижиг саван дахь үнэрт шингэн бодис нь хагас дамжуулагч жижиг ялтсын цоргоор дамжина. Уг хагас дамжуулагч жижиг ялтас нь бэх цацаж хэвлэгч хортой адил харагдах бөгөөд Шнифманы гол цөм нь болох юм. Жижиг цоргоор дамжсан үнэрт бодис тусгай жижиг хавтанцар дээр очиж тодорхой температурт хүртэл халж ууршаад тусгай цоргоор гадагшилж улмаар та бид энэ тэр үнэрийг мэдрэх ажээ.

Хэрэв та "Formel -1" компьютер тоглоомыг тоглож байвал бензиний үнэр ханхлах бөгөөд та хэр сайн тоглож байгаагаас хамаарч өөрөөр хэлбэл хэр хурдтай давхиж байгаагаас хамаарч бензины үнэр их бага харилцан адилгүй хэмжээгээр үнэртэх юм байна.

Шнифман ирэх жилээс эхлэн худалдаанд гарах бөгөөд 2003 оны "СеВГ" буюу компьютер, мэдээлэл, телекоммуникацийн технологийн яармаг худалдаанд түүнийг анх олны өмнө дэлгэн тавьж, 99-149 еврогийн /1euro=1 \$/ үнэр худалдана.

ГЕРМАН ОРНООР СОНИН САЙХАН ЮУТАЙ ВЭ?

Цагаачлалын хуулнд гарын үсэг зуржээ.

Холбооны засгийн газрын санаачилсан Цагаачлалын тухай хуулнд Холбооны ерөнхийлөгч Йоханиес Рау энэ оны 6 дугаар сарын 20-ны өдөр гарын үсэг зурлаа. Уг хуулийн дагуу гадаадынхан Германд цагаачлан орж ирэх явдлыг журамлахын хамт хязгаарласан. Цагаачлалын хууль нь цагаачид орж ирэх, хөдөлмөр эрхлэх, нийгэмд интеграцчилагдах явдлыг дэмжих зэрэг асуудлуудыг зохицуулна.

<http://www.bundesregierung.de>

Шинжлэх ухаан ба интернет номын сан

ХБНГУ-ын Шинжлэх ухаан, судалгааны яам Getinfo / www.getinfo.de/ хэмээх нэгэн шинэ интернет номын санг ашиглалтанд оруулж, байгалийн шинжлэх ухаан, техникийн бүхий л салбар ухааны холбогдолтой мэдээллийг шуурхай түргэн авах боломжийг уншигчдад олгох гэж байна. 4,3 сая еврогийн өртөг бүхий энэ төслийн үр дүнд зөвхөн интернет номын санг байгуулах төдийгүй материалыг хэвлэж худалдах болно. Холбооны засгийн газар эдийн засгийн шинжлэх ухаан (www.econdoc.de), анагаах ухаан (www.dimdi.de)-ны салбарт ийм интернет номын санг хэдийнээ байгуулсан бөгөөд өдгөө нийгмийн шинжлэх ухаан, сэтгэл судлал боловсролын салбарт мөн ийм номын санг байгуулахаар ажиллаж байна.

<http://www.getinfo-doc.de>

Холбооны соёлын санг байгуулжээ.

Холбооны соёлын санг байгуулах санааг 30-аад жилийн өмнө Вилли Брандт, Гюнтер Грасс хэмээх хоёр Нобелийн шагналтан анх сэдсэн боловч тухайн үед янз бүрийн

эсэргүүцэлтэй тулгарсаар хэрэгжүүлж чадсангүй. Харин энэ хавар Халле/Заале/-д уг сан байгуулагдаж үйл ажиллагаагаа эхэлсэн байна. Холбооны соёлын сан нь олон улсын соёлын солилцоог хөхүүлэх, ирсэн цагаач иргэдийг соёлын хувьд интеграцчилагдахад дэмжлэг үзүүлэх зэрэг төслийг хэрэгжүүлнэ. Тус сан 2004 он хүртэл явуулах үйл ажиллагааны хөтөлбөрт зориулан 76,7 сая еврог зарцуулахаар төлөвлөж байна.

<http://www.kulturportal-deutschland.de>

Германд экологийн татварын шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлж байна.

2002 оны 1 дүгээр сарын 1-нээс экологийн татварын шинэчлэлийн дөрөвдэх буюу хамгийн сүүлчийн үе шат хэрэгжиж эхэлсэн билээ. Үүний дагуу нэг литр бензин, дизелийн түлшнээс авах татварын хэмжээг 3,07 центээр, нэг киловатт цагийн татварыг 0,26 центээр тус тус өсгөсөн байна. Холбооны байгаль орчны яамны захилгын дагуу экологийн татвар цаашид ямар нөлөө үзүүлэх талаар судалгаа явуулж, анхны үр дүнг нийтэлжээ. Үүнд: 2002 онд экологийн татварын шинэчлэлийн дүнд 60000 ажлын байр шинээр бий болох бөгөөд 2006 он гэхэд энэ тоо 90000-д хүрнэ. 2002 онд хүрээлэн буй орчинд хортой нүүрсхүчлийн давхар ислийн хэмжээ 7 сая тн-оор хорогдоно. 2006 он гэхэд жил тутам ялгарч буй нүүрсний давхар исэл 9 сая тн-оор хорогдох ажээ.

<http://www.bmu.de>

Өнгөрөгч дөрвөн жилийн хугацаанд германы харъяат болсон гадаад иргэдийн тоо бараг хоёр дахин өсчээ.

Германы харъяалал бүхий гадаад иргэдийн асуудал хариуцсан Холбооны засгийн газрын мэргэжилтэн Марийлуизе Бек 2002 оны 8 дугаар сарын 23-ны өдөр Герман дахь гадаад иргэдийн байдлын тухай мэдээлэл хийж, Германы Социаль Демократ Нам /SPD/, Ногоонтны намын эвсэл засгийн эрхийг

авснаас хойшхи дөрвөн жилийн хугацаанд германы харьяат болсон иргэдийн тоо бараг хоёр дахин өссөн болохыг мэдэгдсэн байна. Гадаад улсын иргэн Германд хүүхдээ төрүүлбэл хүүхэд нь Германы харьяат болохыг 2000 онд зөвшөөрөх болсноос хойш өнгөрөгч хугацаанд цагаач иргэдийн нийт 100000 хүүхдэд германы харьяаллыг шууд олгосон байна.

Олон улсын боловсрол, хөгжлийн германы сан байгуулагдлаа.

Карл Дуйсберг нийгэмлэг /www.cde.de/ болон Германы олон улсын хөгжлийн сан /www.dse.de/ хоорондоо нэгдэж, 2002 оноос Олон улсын боловсрол, хөгжлийн германы сан хэмээн нэрлэгдэн Бонн хотноо төвлөн үйл ажиллагаагаа явуулж байна. Уг сан олон улсын боловсрол, солилцоо, харилцан санал бодлоо солилцох хөтөлбөрийг жил бүр 40000 хүнд зориулан зохион байгуулна.

<http://www.cdg.de/>,

<http://www.dse.de/>